

ТӨВ АЗИ БА ЗҮҮН ӨМНӨД АЗИЙНХАН

(Түүх-угсаатны соёлын харилцаа)

*С.Дашцэвэл**

1.1. Бүс нутаг хэмээх ойлголт

Бүс нутаг хэмээх ойлголт нь нэлээд харьцангуй ойлголт бөгөөд хэд хэдэн төрөлд хуваагдана. Үүнд соёл иргэншлийн бүс нутаг, эдийн засгийн бүс нутаг, улс төр-стратегийн бүс нутаг гэх мэт.

Соёл иргэншлийн бүс нутаг гэдэг нь байгаль-цаг уурын тодорхой нөхцөлд нийтлэг нэгэн ахуй соёлыг олон зуун жилийн турш бүрэлдүүлсэн бүс нутаг юм. Соёл иргэншлийн бүс нутаг нь эдийн засгийн бүс нутгийг бодвол харьцангуй тогтвортой ажээ. Харин эдийн засгийн бүс нь тийм ч тогтвортой бус бөгөөд хөгжлийн аль нэг төвийг тойрон тогтох нь бий. Эдийн засгийн бүс нь соёл иргэншлийн бүстэй тэр болгон давхцаж байх албагүй.

Улс төр-стратегийн бүсийн хувьд бүр ч тогтворгүй бөгөөд тухайн улс үндэстний улс төр, аюулгүй байдлын бодлогоос шууд хамаарч түргэн зуур өөрчлөгдөх хандлагатай. Аливаа бүс нутгийн хувьд газар зүйн хүчин зүйл чухал байдаг боловч орчин үед улс төр-стратегийн бүс нутгийн хувьд газар зүйн хүчин зүйл тийм ч чухал бус болжээ. Учир нь орчин үед яригдах болсон стратегийн болон түншлэлийн, мөн 3 дахь хөршийн орнууд хэдийгээр өөр хоорондоо хол оршив ч улс төр-стратегийн зорилго, үзэл бодлын үнэт зүйлийн хувьд ойр шадар байх нь гол юм.

Бидний оршин аж төрж буй Ази тивд Зүүн Өмнөд Азийн, Төв Азийн, Баруун Азийн, Өмнөд Азийн гэх мэт соёл иргэншлийн олон бүс бий. Монгол орон Төв Азийн нүүдлийн соёл иргэншлийн бүсэд хамаардаг боловч орчин үед Зүүн Хойд Азийн эдийн засгийн бүсэд хамрагдах хандлагатай байгаа нь тийм ч гайхмаар зүйл биш бөгөөд соёл иргэншлийн болон эдийн засгийн бүс гэдэг нь 2 өөр ойлголт гэдгийг харуулж байгаа хэрэг юм.

1.2. Төв Ази ба Зүүн Өмнөд Азийнхан

Монгол туургатан нь Төв Азийн соёл иргэншлийн бүсэд аж төрж ирсэн бөгөөд энэ бүс нутгийнхны иргэншил Зүүн Өмнөд Азийнхаас эрс ялгаатай. Төв Ази нь байгаль цаг уурын хувьд хээр тал зонхилсон эрс тэс хуурай уур амьсгалтай бөгөөд мал аж ахуй эрхлэн амьдрахад илүү зохицсон учир эртнээс нүүдлийн иргэншлийн нэг голомт нутаг болжээ. Харин Зүүн Өмнөд Ази нь жилийн дөрвөн улиралд чийглэг дулаан уур амьсгалтай бөгөөд газар тариалан, ялангуяа усны цагаан будаа тариалахад нэн тохиромжтой тул усны цагаан будааны аж ахуй зонхилсон суурин иргэншлийн нэгэн төв болжээ.

* С.Дашцэвэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Төв Азийн эртний нүүдэлчдийн тухай эрдэмтэд тэмдэглэсэн нь: “Төв Азийн нүүдэлчдийг Өрнийн тал нутгийн нүүдэлчид, Дорнын тал нутгийн нүүдэлчид хэмээн хоёр хэсэгт хуваана. Өрнийн тал нутаг нь Дунай мөрөн, Хар тэнгисээс тэнгэр уулын хойд тал Алтайн нурууны баруун хэсэгт тулж байв. Дорнын тал нутаг нь Тэнгэр уулаас зүүн зүгт Хянганы нурууг давж өмнө зүгт Хималайн уулсаас хойд зүгт Сиян-Алтай, Байгаль нуур хүртэл үргэлжилсэн удам нутгийг хамрана... Дорнын тал нутаг буюу Дотоод Ази нь өвөл, зун, өдөр шөнийн халуун хүйтэн эрс тэс ялгаатай, хуурай цаг ууртай дэлхийн хамгийн хатуу ширүүн уур амьсгалтай бүс болж хувирсаны учир нь өрнийн муссон хэмээх дулаан урсгалыг Тэнгэр уул, Алтай нуруу хааж, Дорнын дулаан урсгалыг Их Хянганы нуруу хаасан өвөрмөц байршилтай нь холбоотой” гэжээ.¹

Энэ бүс нутгийнхан байгаль цаг ууртайгаа зохицсон өвөрмөц ахуй соёлыг бий болгосоноос гадна зүүн баруун талдаа газар тариалан эрхэлсэн суурин иргэншилтэй хил залгаж тэдний аль алинтай нь харилцах таатай нөхцөл бололцоотой байлаа. Ялангуяа өрнө дорныг холбосон торгон замын хөгжилд нүүдэлчдийн оруулсан хувь нэмэр асар их юм. Нүүдэлчдийн тэмээн хөсөг, морин хөсөг, торгоны их замын хөдөлгөөнд гол оролцогч байжээ. Ийнхүү Зүүн ба Зүүн Өмнөд Азийг Ойрхи Дорнод Европтой холбож, өрнө-дорнын ард түмэн харилцан нэвтрэлцэж нийгэм соёлын солилцоо хөгжихөд Төв Азийнхан чухал үүрэгтэй байжээ.

Зүүн Өмнөд Азийн соёл иргэншлийн бүсийн хувьд түүхийн эрт үед умар зүгт Хөх мөрөн, баруун зүгт Умард Энэтхэг буюу Ассам, зүүн ба өмнө зүгт Номхон далайн арал ба хойгуудыг хамарч байжээ. Энэ өргөн удам бүс нутаг нь өвөрмөц нэгэн нийтлэг соёл иргэншлийн өлгий нутаг байв. Энэхүү соёл иргэншил олон зуун жилийн турш бусад соёл иргэншилтэй айлсан нэвтрэлцэж хүн төрөлхтний соёл иргэншилд өөрийн гэсэн хувь нэмрийг оруулсаар хил хязгаар нь ч тэлэгдэх хумигдах хувирлыг үзсээр өнөөгийн зуунтай золгожээ.

Төв Ази нь хүн төрөлхтний эртний өлгий нутгийн нэг бөгөөд хуучин болон шинэ чулуун зэвсгийн бие даасан соёлтой хүрэл зэвсгийн соёлын баялаг түүхтэй бүс нутаг гэгддэг бол Зүүн Өмнөд Ази нь мөн л Homo sapiens буюу оюун ухаант хүний өлгий нутаг төдийгүй усны цагаан будаа тариалж эхэлсэн өлгий нутаг гэгддэг. Мөн шинэ чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн дархчуулаар алдаршсан гэх мэт соёл иргэншлийн олон зүйлээр дэлхийн дансанд орсон бүс нутаг билээ.

1.3. Төв Азийн нүүдэлчдийн тархалт өмнө зүгт

Манай гариг дээр 4 удаа их мөстлөг болсны хамгийн сүүлчийнх нь хуучин чулуун зэвсгийн сүүлч буюу одоогоос 100 мянган жилийн

тэртээ тохиожээ. 20 мянган жилийн тэртээ тэрхүү мөстлөг туйлдаа хүрч, 10 орчим мянган жилийн тэртээ мөстлөгийн үе шувтарсан гэдэг.²

Сүүлчийн мөстлөгийн үед хүмүүс гал хэрэглэж агуйд суух болсон ба багаж зэвсэг нь боловсронгуй болж, хэл яриа нь хөгжив. Тэр үед өмнөд далайн усны түвшин үлэмж доошилж далай тэнгисийн усны хүзүүвч ил гарч эх газрыг холбосон бөгөөд умард тивд зарим арал тивүүд мөсөн гүүрээр холбогдож нийлэх болсон нь эртний хүмүүсийн шилжилт хөдөлгөөнд дөхөм болжээ. Энэ үеийн мэдэгдэж буй хамгийн анхны нүүдэл гэвэл умард Азиас Америк тив рүү чиглэсэн их нүүдэл билээ.

Мөн үед хүйтэн жихүүн умар зүгийн хүн амьтан бүлээн дулаан өмнө зүгт суурьших нь үлэмжхэн байжээ.³ Мөстлөгийн сүүл үеэр Австрали, Шинэ Зеландын далайн түвшин доошилсноос Зүүн Өмнөд Азийнхан Австрали болон далайн бусад арлуудын зүг нүүдэллэн суурьшиж байсны ул мөр одоо ч олдсоор байна.⁴

Ийнхүү Умард Азиас Америк тивийн зүг, мөн Умард Азиас өмнөд далайн бүс рүү, Өмнөд Азийн арлуудаас Номхон далайн арлууд руу шилжин суурьших хөдөлгөөн нилээд эрчимтэй байсны ул мөр археологийн олдвор, ялангуяа хуучин болон шинэ чулуун зэвсгийн элдэв зүйл олдвороор нотлогддог байна. Умард Ази, Төв Азид байдаг хуучин болон шинэ чулуун зэвсгийн олдвор Төвдийн өндөрлөг, Зүүн Хималайн орчим газарт олдсоор байгаа бөгөөд мөн Зүүн Өмнөд Азийн эх газарт тархсан шинэ чулуун зэвсгийн болон хүрлийн эхний үеийн дурсгалууд Номхон далайн өмнөд арлууд болон Австралид олдсоор байна. Энэ нь эртний хүмүүсийн шилжилт хөдөлгөөн болон тэдний ахуй соёлын харилцаатай нягт холбоотой юм.

Одоо бид монголжуу төрхтөн хэдийд өмнө зүгт тархсан тухай мэдээллийг сонирхоё. Хүмүүн төрөлтний арьсны өнгөөр ялгаран төлөвших үйл явц дунд буюу шинэ чулуун зэвсгийн үед буюу одоогоос 7-8 мянган жилийн тэртээд үндсэндээ дууссан хэмээн үздэг. Тэгвэл хуучин чулуун зэвсгийн дээд үед буюу одоогоос 40-14 мянган жилийн тэртээ Монгол, Төвд, Туркстан, Манжуур, Сибирьт монголжуу шар арьстаны овог нутаглаж байсан ажээ. Мөн үед Хятадын хоёр мөрний хооронд тийм шар арьстаны өөр нэгэн салаа мөчир оршиж байсан тухай хятадын эрдэмтэн Бай Шоули “Хятадын ерөнхий түүхийн хураангуй тойм” номондоо дурдсан байна.⁵

Дунд болон шинэ чулуун зэвсгийн үе гэхэд Төв Ази, Зүүн Ази, Зүүн Өмнөд Азийн умард хэсэг, Энэтхэгийн хойт хэсэг нэгэнт монголжуу шар арьстан тархсан байсан тухай, мөн тэр үед Ойрхи Дорнод, Дунд Ази, Энэтхэгийн баруун хойт хэсэгт европжуу цагаан арьстан нутаглах болсон тухай эрдэмтэд нэг биш удаа тэмдэглэсэн байна.⁶ Вьетнамын эрдэмтэн Нгуен Динь Кхоа Зүүн Өмнөд Азийн

угсаатны судлалын томоохон бүтээлдээ “Шинэ чулуун зэвсгийн дараах хүрэл ба төмөр зэвсгийн үед ЗӨА-ийнханы ихэнхи нь монголжуу шар арьстан болсон” хэмээн дурдсан бий.⁷ Үүнээс үзвэл дунд ба шинэ чулуун зэвсгийн үед умар зүгээс Зүүн Өмнөд Ази руу шилжих хөдөлгөөн эхэлсэн бөгөөд хүрэл ба төмөр зэвсгийн үед Зүүн Өмнөд Ази даяар монголжуу шар арьстан нэгэнт тархсан ажээ. Гэхдээ монголжуу шар арьстаны умардын болон хятадын гэх хоёр салбар хоёул тархсан нь мэдээж. Нэг нь умард Азиас Зүүн Химлайн чиглэлээр нөгөө нь хятадын хоёр мөрний хоорондоос Зүүн Өмнөд Ази руу нэвтэрсэн байна. Тийм ч учраас сүүлийн үеийн хүний генийн судалгаагаар монгол төв Азид нэн түгээмэл тохиолддог HLA системийн A33-B58-CW3 гоплотин төв хятадад байдаггүй атал ЗӨА-ийн зарим үндэстнүүдэд илэрдэг ажээ.⁸ Үүнтэй зэрэгцэн умардын угсаа соёлын нөлөө ч мөн хоёр замаар тархсан гэх үндэстэй юм.

Төв Азийн нүүдэл суудлын тухай эрдэмтдийн тэмдэглэлд “өрнийн тал руу юм уу зүүн тийш Хянганы нуруу давж нүүдэл хийх нь голдуу ган гачгаас мал сүргээ хамгаалах, отог овгоороо нутаг сэлгэн нүүх, бэлчээр нутгийг эзлэн авах зорилготой байсан бол өмнө зүгт нүүдэллэгсдийн ихэнх нь дайн дажны үр дүнд хүчээр хуваагдах, омог аймгаараа амь зулбаж оргон зайлах гэх мэт эрт ба дундад үеийн олон удаагийн дайн самуун элдэв хавчлага дарлалаас зугтагсад байв” хэмээсэн байх нь олонтаа билээ. Нийтийн тооллын өмнөх 1 дэх мянган жилд Төв Азийн нүүдлийн болон хагас нүүдлийн олон аймгуудын нэгдэл бутрал үргэлжилж, эртний хэд хэдэн төр улсыг бүрэлдүүлж, улмаар овгийн байгууллаас анхны төрт нийгмийн байгуулалд шилжсэн билээ. НТӨ I мянганы эцсээр Хүннү нар мэдэгдэхүйц хүчирхэг болж Байгаль нуураас Зайсан нуур, Их говиос Тэнгэр уулын умард салбар хүртэл удам газрыг эзэлж байв.⁹ Хүннү улсыг Модун Шаньюй толгойлох болсон тэр үед хүчин чадал нь нэн ихсэж баруун зүгийн хөрш аймгууд руугаа довтолж, өмнө зүг давшиж газар нутгаа тэлэв. Үүнээс үүдэн Хүннүгийн баруун талд Тэнгэр уулын хойгуур байсан нүүдэлчин овог аймгууд баруун зүгт шилжин нүүжээ.¹⁰ Тэд Тэнгэр уулын умард талаас Памирыг давж Кашмирын орчим хүрчээ. Нөгөө хэсэг нь Амударья мөрний савд очжээ.

Төв Азийн худалдааны гол замыг эзэмшихийн төлөө Хүннү улс Хятадын Цинь улсын хооронд тэмцэл хурцдаж эцэст нь Хүннүгийн ялалтаар төгсөв.

Төв Азид нүүдэлчдийн Хүннү улс олон жил ноёрхсон боловч НТ-ын эхээр их ган гачиг давхцаж өөр хоорондоо тэмцэлдэж хүч нь сулраад хэд хэд хуваагдан ийш тийш тарж бутарчээ. Л.Н.Гумилевын

тэмдэглэснээр нэг хэсэг нь Европ руу шилжиж, нөгөө хэсэг нь Долоон мөрний хавьд суурьшиж, зарим нь Цагаан хэрмээс урагш нүүжээ.¹¹

Харин Ордос, Хөх нуур хавьд байсан өмнөд Хүннү нар Сяньби угсааны овог аймгуудтай нэгдэн хожим нь нилээд хүчирхэгжсэн байна.

Хан улс мөхсөний дараа нийтийн тооллын 3-р зуунд Хятад орон нэгдмэл байдлаа алдаж биеэ даасан 3 улс болон хуваагдсан. Үүнийг Хятадын түүхэнд 3 улсын үе хэмээдэг. Энэ нь Умард Хятадын Вэй улс, Баруун Хятадад Чэндү хотоор нийслэсэн Шу улс, Хөх мөрний эрэг дээрх Нанжин хотод нийслэсэн Ү улс билээ. Шу улсын хүн амын зонхилох хэсэг нь төвд-бирм хэлтний өвөг дээдэс байсныг эрдэмтэд тэмдэглэж байна. Энэ үеийн Вэй улс, Шу улсын бүрэлдэхүүнд Төв Азийн нүүдэлчин овог аймгууд олноор байжээ.¹²

Ер нь Төв Азийн нүүдэлчин овог аймгуудын өмнөд хязгаар нь Төвдийн өндөрлөг, Хөх, Шар мөрний эх, Хөх нуур, Сычуаны баруун ба умард хэсгээр байсан бөгөөд зүүн Хималайн хятад биш олон овог аймгуудтай хил залгаа байсан билээ. Тэрхүү зүүн Хималай, Сычуань, Юнань хавьд оршин суугч хятад биш үндэстнүүдийн зонхилох хэсэг нь одоогийн Энэтхэг-Хятадын хойгийн умард хэсэгт оршин суугч төвд-бирм хэлтнүүд болон тай, мяо нарын өвөг дээдэс байв. Нийтийн тооллын 265 онд Вэй улсын цэргийн жанжин Сыма Янь нь төрийн эрхийг авмагц Ү болон Шу улсыг нэгтгэн шинэ Цин (265-420) улсыг байгуулав. Энэ үед Цин улсын төрийн хэрэгт умардын нүүдэлчид мөн л идэвхитэй оролцох болсон тухай академич Н.Ишжамц тэмдэглэсэн байна.¹³

Төдөлгүй Цин улс нүүдэлчдийн ээлжит довтолгоонд нэрвэгдсэн бөгөөд Ордос хавьд нутаглаж байсан нүүдэлчид нэгдэж Цин улсын нийслэл Чань Ан-ыг эзэлсэн бол Сяньби угсааны Тоба нар баруун хойд Хятадыг эзэлж Лоян хотоор нийслэлсэн умард Вэй улсыг байгуулав. Хятад орон даяар дайн самуун үргэлжилж зах хязгаарын хятад бус овог аймгуудад нэн халгаатай үе болсон тул хятадын баруун болон өмнөд хязгаарын хятад бус үндэстнүүдийн урагш шилжин нүүдэллэх нь үлэмж болжээ. Ялангуяа Тан улсын үе болон Хятадын феодалын бутралын үе буюу 5 төр, 10 улсын (X зуунд) үед дотоодын дайн самуунаас дайжиж хятадын өөрийн иргэд ч өмнө зүг дүрвэн шилжих нь нэн их байсан тухай Хятадын түүхэнд олонтаа тэмдэглэсэн байдаг.

Нэг үгээр хэлбэл нийтийн тооллын эхээр Химлайн зүүн бэлээр байсан хятад биш овог аймгууд Төв Азийн нүүдэлчидтэй айлсан хил залгаа байсан бөгөөд зарим үед нэг захиргаан дор орж гарч байснаа дараа дараагийн үед тэд бага багаар урагшилсаар одоогийн Энэтхэг, Хятадын хойгт очиж суурьшсан байна.

1.4. Зүүн Өмнөд Ази дахь умардынхан

Судалгаанаас үзвэл одоогийн Зүүн Өмнөд Азийн умард их газарт оршин суугаа Бирм, Тайланд, Лаос, Вьетнам зэрэг улс үндэстнүүдийн бүрэлдэхүүнд багтдаг Качин, Шан, Тай, Монг, Мяо, Зао, Лоло, Лаху, Нүнг ястнууд түүхэн эрт цагт умараас өмнө зүгт аажим аажмаар шилжин одоогийн нутаг дэвсгэрт очиж суурьшигсад юм.

Тэд Энэтхэг-Хятадын хойгийн уугуул иргэд болох австронезийн бүлэг хэлтнүүдийг нутгийн уулархаг хязгаар луу аажмаар түрж Меконг, Иривади, Улаан мөрний үржил шимт хөндийд суурьшжээ. Харин өдгөөгийн Камбож буюу Мон-кхмерүүд үндсэн нутгаасаа төдийлөн шилжээгүй өдий хүрчээ.

Энэтхэг-Хятадын хойгийн эртний уугуул оршин суугчид нь австролойд хэв маягийн өнгөт бор арьстан байсан бөгөөд тэд одоо Энэтхэг-Хятадын хойгийн олон оронд үндэстний цөөнх болон аж төрж, тус хойгийн ард түмний соёл иргэншилд хүчтэй нөлөөлж, түүх угсаатны соёлын нэгэн чухал бүрэлдэхүүн болсоор байна.¹⁴

Төвд-Бирм хэлтэн болон Тай, Лао нарын дээд өвөг нь Төвдийн өндөрлөг, Шар мөрөн, Хөх мөрний эхээр байгаад хожим нь Сычуань хавьд эртний Шу улсын овог аймгуудын олонхи байсан бөгөөд НТ-ын эхээр урагш нүүж одоогийн Хятадын Юнань мужийн баруун ба өмнө хэсэгт сууршиж улмаар одоогийн Энэтхэг-Хятадын хойгт очсон хэмээн олонхи эрдэмтэд үздэг ажээ. Ийнхүү умраас өмнө зүг шилжин суурших үйл явц мэдээж олон зуун жил үргэлжилсэн ажээ. Энэ нь лавтайяа таван мянган жилийн тэртээгээс 20-р зууны 30-аад оныг хүртэл үргэлжилсэн үйл явц ажээ.

Бирмийн өвөг дээдсийн нэг хэсгийг Руу, Chiang хэмээх эртний нүүдэлчид гэх бөгөөд түүхийн эрт цагт Түвдийн өндөрлөг ба Их говийн хооронд суурьшиж байгаад улмаар Түвд угсаатантай холилдон сууршиж дараа нь урагш нүүдэллэсэн хэмээн профессор Нгуен Динь Кхоа “Зүүн Өмнөд Азийн угсаатны судлал” бүтээлдээ тэмдэглэжээ.¹⁵ Тэд НТӨ II мянган жилээс НТ –ын I мянган жилийн дунд үед Умард Бирмийн нутагт шилжиж, НТ-ын I мянган жилийн эцэс гэхэд нэгэнт Иривади мөрний хөндийд суурших болсон гэжээ.¹⁶

Ийнхүү Бирмийн өвөг дээдсийн нүүдэл суудлын тухай янз янзаар бичсээр буй. Энэтхэг-Хятадын хойг дахь төвд-бирм хэлтний бүрэлдэхүүнд одоо 40 орчим сая хүнтэй Бирм, мөн Карен, Качин, Чин, Каяа, Лоло, Хани, Лаху... гэх мэт олон овог ястнууд багтаж байна.

Англи, Франц болон зарим барууны эрдэмтэд Тайландын өвөг дээдэс нь Төвдийн өндөрлөгт байж байгаад одоогийн Сычуань, Юнаны нутгаар дамжин Энэтхэг-Хятадын хойгт суурьшсан хэмээн бичсэн нь олонтаа. Тай нар НТӨ II мянганы үед Хималайн зүүн

хормойд Сычуаны баруун умард нутгаар байсан бөгөөд түүнээс өмнөх үед чухам хаана байсан нь төдийлөн тодорхой биш. Америкийн эрдэмтэн W.C.Dodd, Тайландын эрдэмтэн Kunwijitmatra, Manikh Jamsai нарын бүтээлд Тай нарыг одоогоос таван мянган жилийн тэртээ Төв Азийн Алтай нурууны чанад, дараа нь Шар мөрний эхээр дараа нь Хөх мөрний хөндийд байсан гэж дурджээ.¹⁷ Ийм ойлголт Тайландад өнгөрсөн зууны 70-аад оныг хүртэл нэлээд өргөн дэлгэрсэн бололтой байдаг. Тухайлбал 1976 оны 6-р сард болсон МАХН-ын 17-р Их хуралд ЛАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүн, БНАЛАУ-ын Ерөнхий сайдын орлогч дарга Фуми Вонгвичит оролцож хэлсэн үгэндээ “...Түүхээс үзвэл бидний өвөг дээдэс бидний зан заншил, уламжлал хэдэн мянган жилийн өмнөөс нягт холбоотой байжээ” хэмээсэн нь монгол, тайландын өвөг дээдэс эрт дээр үеэс ойр дөт байсныг сануулан дурдсан хэрэг юм.¹⁸

Тай нарын өвөг дээдэс түүхэн эрт цагт чухам хаана байсан бэ? гэдэг нь нэлээд маргаантай бөгөөд шинэ чулуун зэвсгийн үед одоогийн өмнөд хятадын Хөх мөрний өмнөх өргөн уудам нутагт угсаатны хувьд бүрэлдэн буй болсон хэмээн оросын эрдэмтэн Д.В.Деопик, А.И.Кузнецов нар үзжээ.¹⁹ Өмнөд Хятадын эрдэмтэн Cheng Lufan 1990 онд бичсэн “Тай нарын гарал үүслийн судалгаа” хэмээх ганц сэдэвт бүтээлдээ Тай нарын өвөг дээдэс Өмнөд хятадын Юнань мужийн өмнө талд Энэтхэг-Хятадын хойгийн хойт хилийн дагуух гүн хавцал өндөр уулын тэгш өндөрлөгт эрт дээр үеэс аж төрж байсан овог ястан” хэмээжээ.²⁰ Ийнхүү Тай нар одоогийн нутагт буюу Энэтхэг-Хятадын хойгт хэзээ хаанаас очсон тухай эрдэмтдийн санал нэгдмэл биш боловч түүхэн өөр өөр үед хэсэг хэсгээр өмнө зүг шилжиж нэлээд хожуу Энэтхэг-Хятадын хойгт очиж суурьшсан нь тодорхой билээ. Ямартай ч НТӨ I мянганы дунд үед тай нарын овог аймгууд Хөх мөрний сав газраас баруун өмнө зүгт шахагдсан бөгөөд НТ-ын эхээр Энэтхэг-Хятадын хойгт дөхөж очоод IX-XIII зуун гэхэд одоогийн нутагт олноор шилжин суурьшсан хэмээх үзэлд олонхи эрдэмтэд санал нэг байна. Хамгийн анх очсон тай хэлтэн нь умард вьетнам дахь Nung, Tay нар бөгөөд тэд НТӨ IV-III зууны үед Хөх мөрний сав газар байгаад умард вьетнамын уулархаг нутгаар очиж суурьшсан байна.²¹ НТӨ-өөс эхэлсэн Тай хэлтэн овог аймгуудын өмнө зүг чиглэсэн нүүдэл НТ-ын дунд үеэс 12-13-р зуунд үлэмж эрчимтэй болсон аж. Тайландын өвөг дээдэс XII-XIII зуунд Энэтхэг-Хятадын хойгт олноор шилжин очихдоо өөрийн Мыонг буюу сууринг байгуулж аажим аажмаар уугуул нутгийнханыг уулархаг хязгаар луу шахаж заримтай нь зэрэгцэн аж төрөх болсон байна.

Одоо бид Зүүн Өмнөд Азийн Тайланд, Лаос, Вьетнам, Бирм ба Өмнөд хятадад тархан суурьшсан Мяо, Зао (Яо) нарын нүүдэл суудлын тухай өгүүлье.

Хятад болон Мяо нарын дунд түгээмэл тархсан эртний нэгэн домогт “Мяо нарын өвөг дээдэс Шар мөрний умар зүгт байгаад хожим Чи нарт эзлэгдэн улмаар Хятадын Хуандийн үед хятадад цохигдон Шар мөрнийг туулж дараа нь өмнө зүг шилжсэн” хэмээн дурджээ.²²

Францын эрдэмтэн Ф.М.Савина 1924 онд Гонконгд хэвлүүлсэн “Мяо үндэстний түүх” номондоо нийтийн тооллын өмнөх олон зууныг шар мөрний хөндийд өнгөрөөж Цинь Ши Хуандийн үед Хятад дахь дайн дажнаас дүрвэж өмнө зүгт нүүж очсон үндэстэн гэж бичсэн бий.²³

Мяо, Яо үндэстэн эдүгээ баруун өмнөд хятадад олноор оршин суудаг бөгөөд тэдний нэг хэсэг мөн л түүхийн өөр өөр цаг үед Энэтхэг-Хятадын хойгт нүүдэллэн очсон байна. Тэднээс хамгийн эрт очсон нь Яо буюу Зао нар ажээ. Тэдний нүүн очсон үеийг НТ-ын XI-XII зуунд хамруулдаг. Яо нар нь угтаа Мяо нарын нэг салбар бөгөөд тэдний хэл VIII-IX зуунд салсан ажээ. Хятадаар Яо хэмээн нэрлэх энэ үндэстнийг вьетнамд Зао хэмээнэ.

Мөн VIII-XIX зууны заагаар Энэтхэг-Хятадын хойгт очиж суурьшсан Мяо нар XIX зууны эцэс XX зууны эхээр хоёр дахь удаагаа олноор нүүн очсон байна.²⁴

Вьетнамын өвөг дээдсийн хувьд нийтийн тооллын өмнөх 1-р мянган жилд одоогийн Өмнөд хятадын далайн эргээр австроази болон австронези хэлтэн овог аймгуудтай хаяа нийлэн заримдаа холилдон сууж байсан нь тодорхой байна. Тэд өмнөд хятадын нутаг, одоогийн Гуандун, Гуанси муж, Вьетнамын умард хэсгээр байж байгаад Цинь улсын цэргийн довтолгоонд өртөж одоогийн умард вьетнамын нутагт очсон тухай вьетнамын болон дэлхийн эрдэмтэд нэгэн дуугаар тэмдэглэдэг. Вьетнамын нэрт түүхч Dao Duy Anh, Францын эрдэмтэн L. Aurutsaux нар өөрсдийн судалгаанд НТӨ 221 онд Вьет нарын бараг бүх нутгийг Цинь улс эзлэн авч зүүн далайн эргээр орших Вьет, мөн Намвьет, Манвьет цөм бага багаар хятадчилагдаж зөвхөн баруун уулархаг нутгаар байсан Тай-Ау, Лак-вьет нар Цинь улсын довтолгоог хүчтэй эсэргүүцэж өмнө зүгт өөрийн вант улсуудыг байгуулсаныг дурдсан байна.²⁵ Энэ үед вьетнамын нэг хэсэг Цинь улсын цэргийн довтолгооноос дайжин урагшилж одоогийн умард вьетнамын нутагт очжээ. Цинь Шихуанди өмнөд зүгийн хятад биш овог аймгуудыг өөртөө нэгтгэсэн боловч баруун болон баруун өмнөд дахь овог аймгууд хүчтэй эсэргүүцэж хятадад эзлэгдсэнгүй ийнхүү үлдсэн ажээ.²⁶ Вьетнам гэсэн нэрийг тэдэнд хятадууд өгсөн бөгөөд Өмнөд Юе буюу өмнөд нутаг руу давж одогсод гэсэн утгатай ажээ.

1.5. Төв Ази ба Зүүн Өмнөд Азийн угсаатны соёлын хамаарал

Төв Ази ба Зүүн Өмнөд Азийн угсаатны соёлд бие биендээ нөлөөлсөн буюу нийтлэг төстэй зүйл бишгүй ажиглагдах ажээ.

Монгол, Төв Азийн үндэстнүүдийн дунд өөрийн үүсэл гарвалыг тэнгэртэй холбодог домог түгээмэл. Жишээ нь Сяньбийн хаан Тяньши Хуайн эх нөхрийгөө Хүннү-гийн цэрэгт яваад байхгүй хооронд нэгэн тунгалаг өдөр тэнгэр дуугарч дээш хартал аманд нь мөндөр орсноор жирэмслээд хүүг төрүүлсэн гэдэг домог бий. Мөн Чингисийн дээд эмэг Алунгоо өөрийн нөхөр Добу мэргэнийг нас барснаас хойш тэнгэрээс буусан гэрлээс жирэмсэн болсон домогтой. Үүний адил Лао, Тай нарын домогт Phya Theng хэмээх тэнгэрийн эзэн өөрийн хүү Khun Borom-ыг газарт илгээснээр түүнээс Тай, лаосын өвөг дээдэс салбарлан бий болсон гэжээ.²⁷ Мөн өөр нэгэн домогт Кхүн Бором тэнгэрээс бууж ирэх үед нэгэн том хулуу олжээ. Түүнийг хага цохитол эрэгтэй эмэгтэй хүмүүн гарч түүнээс одоогийн олон овог аймгууд салбарлан үүссэн гэх.²⁸ Энд нэг зүйлийг анзаарахад дээр дурдсан Theng хэмээх үг “Тэнгэр” гэсэн утгатай бөгөөд Тай, Лао хэлэнд “Хүн” гэхийг “Khon” буюу “Khun” гэдэг нь тохиолдлын хэрэг биш байлтай. Хожмын эрдэмтэд үүнийг лавшруулан судлана бизээ.

Дээд тэнгэрийн үзэл ба тэнгэрийн шүтлэг Эртний Энэтхэгээс Иран, Иранаас Дунд Ази, Төв Азид тархсан байж магадгүй хэмээн зарим эрдэмтэд үздэг билээ. Энэ нь *Хурмаст тэнгэр* буюу *Хан хормустын* тухай үзэл ойлголттой холбогдуулан тайлбарласан зүйл билээ. Хурмаст буюу Хормуст хэмээх энэ үг эртний персийн дээд бурхан шүтээний нэр гэж оросын эрдэмтэн Г.Н.Румянцов тэмдэглэсэн буй. Монгол домогт баруун зүгийн 55 тэнгэрийн тэргүүн Хан хурмаст гэх мэтээр дурдсан байдаг. Монголын бөө мөргөлчид Хурмастыг тэнгэр бурхан буюу тэнгэр хэмээн үздэг. Хурмаст хэмээх энэ үг хэдийд монголд дэлгэрснийг мэдэхэд амаргүй боловч Дунд Азийн дээд бурхан – Хормустын үзэл санаа Төв Азид нэвтрэх үед Хормустыг тэнгэрийн хан мэтээр ойлгох болж монголд Хан Хормуст ба Хормуст тэнгэр хэмээх нэр томъёо тархсан байна. Оросын эрдэмтэн П.Б.Коновалов монголчуудын тэнгэр шүтлэгийн тухай судалгаандаа “Персүүд тэнгэрийг бурханчлан Ормузда буюу Хормуст гэх болсоныг дурдаад Монголчууд Хормуст тэнгэрийн тухай ойлголтыг Персээс авсан гэжээ.²⁹ Чухам хэдүйд авсан бэ? гэдгийг эрдэмтэд үзэхдээ исламын шашин дэлгэрч нутгийн шашин суртлууд Төв Азийн тал нутаг руу шахагдаж орсон тэр үетэй холбон тайлбарлаж байна. Иранд исламын шашин 7-р зуунд хүчтэй дэлгэрч Ираны зароастризм хилийн чанад түрэгдсэн гэж үздэг. Иймд энэ үед Хормуст тэнгэрийн тухай ойлголт Төв Азид

нэвтэрсэн байж болно. Гэхдээ тэнгэрийг шүтэх үзлийн хувьд бүр Хүннү гүрний үед Төв Азид байсан ажээ. Учир нь НТӨ I мянган жилд Иран-Тюркийн угсаатны соёл бүрэлдсэн бөгөөд бүр хожим НТ-ын I мянган жилийн сүүлийн хагаст түрэгийн соёл давамгайлах болсон хэмээн үздэг.³⁰ Иймд Хүннү гүрний үед Энэтхэг-Ираны соёлтой бид хөрш зэргэлдээ байсны хувьд тэнгэр шүтлэгийн ойлголт нэлээд гүнзгий болсон байх үндэстэй юм. Тэр үед Хүннү нарын тэнгэрийн тухай үзэл нь шашин шүтлэг тал руугаа нэлээд гүнзгийрч байсны шинж буй. Тухайлбал Хүннү нар тэнгэрт мөргөж өргөл өргөдөг ёс байсан, мөн өглөөд наранд оройд саранд мөргөдөг байсан тухай Оросын эрдэмтэн Бичурин тэмдэглэсэн байна.³¹ Хожим нь Хормуст тэнгэр, тэнгэр нэрийн үзэл Персээс Төв Ази руу нэвтэрч Бөө мөргөлийн үзэл ойлголтыг баяжуулан гүнзгийрүүлсэн гэж үзэх үндэстэй юм.

Тэнгэр шүтлэгтэй холбоотой билэгдэл шингэсэн хувцас хэрэглэлийн зүйл Төв Ази болон Зүүн Өмнөд Азид аль алинд нь нэлээд түгээмэл тархжээ. Үүний нэг нь малгайн дээрээ шувууны өд хатгах заншил юм. Шувууны өдийг малгайн оройд хатгах заншил зарим нутагт бөө мөргөлийн ёс заншилтай холбоотой байхад зарим нутагт цэргийн эрх тушаалтнууд хэрэглэдэг байжээ. Одоо бол зарим нутагт үндэсний бүжиг наадмын үед хэрэглэх болжээ.

Дэлхийн олон оронд энэ заншил байдаг боловч хамгийн их дэлгэрсэн газар нутаг нь Төв Ази, Хойт Америк, Умард Энэтхэг хэмээн сулаачид тэмдэглэжээ. Зүүн Өмнөд Азийн хувьд түүний умард уулархаг нутгийн Химлайн уулсын ойролцоох төвд-бирм хэлтэй овог аймгуудын дунд илүү өргөн тархсан байна. Одоогоос 2000 жилийн тэртээх Зүүн Өмнөд Азийн хүрэл бөмбөр дээр малгайн дээрээ шувууны өд хатгасан хүмүүсийн дүрс тод харагдах бөгөөд энэ нь тийм уламжлал Зүүн Өмнөд Азид түүхэн эрт үед дэлгэрснийг гэрчилнэ. Түүхээс үзвэл ЗӨА-ийн эх газрын хойт уулархаг нутгаар аж төрдөг овог аймгууд, тухайлбал Бирмийн Качин зэрэг ястаны эрчүүд тэр үед малгайн дээрээ шувууны өд хатгадаг заншилтай байжээ.³²

Индонезийн зарим арлынханы өдтэй малгайн зориулалт Энэтхэг болон Зүүн Химлайн овог ястнуудынхтай төстэй бөгөөд цэргийн удирдагч, овгийн тэргүүн нар хэрэглэдэг заншил хожмын үе хүртэл хадгалагджээ. Судлаач Хейне-Гельдрений ажигласанаар Энэтхэгийн Нага ястаны эртний дайчдынх Зүүн Индонезийнхтай нэн төстэй ажээ. Энэ нь Энэтхэг ба Индонезийн эртний түүх-соёлын нягт харилцаатай холбоотой.

Умард Азийнхан шувууны өдийг анх бөө мөргөлтэй холбогдуулан хэрэглэж байсан бөгөөд энэ нь нэн эртний улбаатай ажээ. Тэр нь хожим Зүүн Өмнөд Азийн гүнд нэвтрэхдээ цэргийн буюу ав хомрогын үед хэрэглэдэг эрчүүдийн өмсгөл болсон байна. Энэ нь

Зүүн Өмнөд Азид харьцангуй хожуу буюу ангит нийгэм бүрэлдэж байх үед дэлгэрсэн болох нь тодорхой. Эрт цагт Төв Ази ба умардынхан яагаад шувууны өдийг хэрэглэх болсон бэ? гэвэл тэнгэрийг шүтэх эртний үзэлтэй нь холбоотой нэмээн судлаачид тайлбарладаг. Өөрөөр хэлбэл шувууны өд нь дээд тэнгэрийн элч, дээд язгууртны бэлэгдэл болж хэрэглэгдэж байв. Эрт дээр үеэс монголчууд тэнгэрийг байгаль ертөнцийн сүр хүчит нэг хэсэг бөгөөд бүхнийг эрхшээгч төдийгүй хүн амьтаны хувь заяаг мэдэгч эрхэм дээд зүйл хэмээн шүтэн биширч байсан. Энэ нь эртний хүмүүсийн нэлээд түгээмэл заншил боловч түүнийг гүнзгийрүүлэн ямар нэг тогтолцоот шүтлэгийн хэмжээнд хүртэл хөгжүүлсэн нь чухамдаа дээр өгүүлсэн Төв Ази, Хойт Америк, Умард энэтхэг мөн бөгөөд эдгээр нь түүхэн эрт цагт түүх-угсаатны соёлын илүү нягт харилцааны хүрээнд байсан бүс нутаг билээ.

Одоо өөр нэг нийтлэг заншлын тухай өгүүлье. Умардын нүүдэлчдийг Хятадууд “гээгт боолууд” хэмээн доромжлон нэрлэж байсан. Мөн нүүдэлчин Тавгач нарыг хятадууд “гээгтэн нар хэмээдэг байв.”³³ Үсээ сүлждэг ёс Төв Азийн нүүдэлчдийн эртний заншил байжээ. Одоо ч энэ заншлаа хадгалсаар байна. Харин Зүүн Өмнөд Азид байдал өөр байв. Тэд халуун дулаан чийглэг уур амьсгалдаа зохицуулж голдуу богино үстэй байхаас гадна ургуулах тохиолдолд ер сүлждэггүй задгай орхидог ажээ. Гэтэл Зүүн Химлайн зарим ястан, ялангуяа Төвдийн өмнөд хөрш, Бирмын умард нутгаар, улмаар Энэтхэг-Хятадын хойгийн умард уулархаг нутгаар оршин суугч үндэстэн ястануудын дунд гээг сүлжих ёсон мэр сэр байдгийг судлаачид ажиглажээ. Эдгээр овог ястанууд голдуу эрт цагт умар зүгийн нүүдэлчидтэй хил залгаа байсан овог ястанууд ажээ.

Мөн зулай дээрээ үс үлдээж дагзан дээрээ эвэр мэт хөхөл талбих ёсон монголчуудад эртний уламжлалтай. Энэ нь зулай дээр хүний амин сүнс орших бөгөөд түүнийг бусдаас далдлах хамгаалах ёстой гэсэн үзэл ойлголттой холбоотой. Гэтэл энэ заншил Зүүн Химлай, Энэтхэг-Хятадын хойгийн зарим үндэстэн ястануудын дунд бас байдаг нь нэн сонин.

Эвэр хэлбэрийн хөхөл нь эрт цагт хүч чадлын бэлэгдэл болгож байсны ул мөр билээ. Монголчууд одоо ч гэсэн эрхтэн дархтнуудыг эвэртэн туурайтан хэмээн хэлдэг нь үүнтэй холбоотой. Тан улсын үеийн он дарааллын бичигт Мяо нарын эвэр үсийг дурдсан байх ба Зүүн Өмнөд Азийнхан одос үхрийн том эврийг хаан вангийн ордонь гол шүтээн болгон тавьсан байх нь элбэг. Тэр нь мөн л хаан төрийн хүч чадлыг бэлэгдсэн хэрэг. Ер амьтаны эврийг хүч чадлын бэлэгдэл болгон малгай толгойндоо дүрслэх заншил евроазид эрт дээр цагаас дэлгэрсэн гэх бөгөөд үүнийг нүүдэлчид бусад тивд түгээсэн гэх үзэл ч байдаг байна. Юутай ч энэ ёс монголын тал нутгаас Зүүн Химлай, улмаар Энэтхэг-Хятадын хойгийн умард уулархаг нутгийг хүртэлх өргөн уудам

нутагт тархсан байна. Энэ нь Юнань, Сичуань дахь И, Мяо үндэснүүдийн дунд элбэг тохиолдохоос гадна эдүгээ Энэтхэг-Хятадын хойгийн умард нутгийн уулынханы дунд мөн байсаар ажээ. Хятад сурвалжид “Хятадын Хуанди хаан Шар мөрний сав газрын оршин суугчдыг захирч байх үед өмнө зүгийн овог аймгуудыг захирагч Чи улстай байлдав. Чи нар толгой дээрээ бэх бат эвэртэй бөлгөө” гэжээ.³⁴ Уг заншлыг хятад сурвалжид ихэд хачирхан тэмдэглэж байсныг бодход хятадад тийм заншил байгаагүй бололтой.

Төв Ази болон Зүүн Өмнөд Азийнханы хувцас хунарын зүйлд нийтлэг төстэй зүйл үлэмж билээ. Юуны өмнө Оросын (хуучнаар Зөвлөлтийн) ШУА-ын эрдэмтэн мэргэд энэ талаар хангалттай судалгаа хийснийг дурдууштай. Эрдэмтэн Я.В.Чеснов “Историческая этнография стран Индокитая” хэмээх чамбай судалгаандаа энэ талаар олон сонирхолтой мэдээллийг багтаасан байдаг билээ. Үүнийг ашиглан зарим нэг зүйлийг танилцуулья.

Зүүн Өмнөд Азийнханы гол өмсгөл нь халуун дулаан уур амьсгалд зохицсон бүсэлхийгээр ороосон задгай сари маягийн хувцас, мөн суга бэлхүүс задгай хувцас өргөн тархсан ажээ. Иймд үүнийг Зүүн Өмнөд Азийнханы уламжлалт гол хувцас гэж хэлж болно. Гэвч Зүүн Өмнөд Азийнханы хувцсанд бусад бүс нутгийнханы хувцас хунарын зүйл нэвтэрч хэрэглэгдсээр хэлбэр загварын хувьд үлэмж баяжжээ. Жишээ нь Төв Азийнхан буюу нүүдэлчдийн зохион бүтээсэн гэгдэх гуя шилбээр битүү шалбуур өмдийг Зүүн өмнөд Азийнхан ялангуяа Энэтхэг-Хятадын хойгийн уулынхан нэлээд эрт дээр үеэс хэрэглэх болжээ. Энэ тухай Оросын эрдэмтэн Я.В.Чеснов “Түүхэн этнографын хувьд тус бүс нутагт шалбуур өмд хэрэглэх болсон явдлыг Азийн бусад бүс нутгаас авч хэрэглэсэн зүйл” хэмээн үзжээ.³⁵ Германы эрдэмтэн Р.Хейне-Гельдерн үзэхдээ эртний Тайчууд нүүдэллэн ирэхдээ тэр өмдийг Энэтхэг-Хятадын хойгт дэлгэрүүлсэн гэжээ.³⁶ Мөн эрдэмтэн Х.Хансен манай эриний босгон дээр Шан нар Бирмд нүүдэллэн ирсэнтэй холбогдуулан тайлбарлажээ.³⁷ Оросын эрдэмтэн Я.В.Чеснов шалбуур өмд нь морь унах болсонтой холбогдон Төв Азийн аж ахуй соёлын хэв шинжийн бүсээс Зүүн Өмнөд Азид тархсан зүйл гэсэн санал дэвшүүлсэн байна.³⁸ Ер нь Зүүн Өмнөд Азийн Бирм, Тайланд, Лаос, Вьетнамын умард нутгийн үндэстэн ястануудын хувцас хунарын зүйлд Төв Азийн нүүдэлчдийн хувцастай төстэй шинж төрх үлэмж ажиглагддаг билээ. 1970-аад оны эцсээр вьетнамын олон ястаны хувцас хэрэглэлийн үзэсгэлэн Улаанбаатарт нээгдсэн бөгөөд энэ үзэсгэлэнгээс нүүдэлчдийн хувцас хунартай нийтлэг төстэй зарим зүйлийг ажигласанаа бичиж “Вьетнам үндэсний хувцас соёлын нэгэн сан” хэмээх өгүүлэл хэвлүүлж билээ. Тэнд тавигдсан үзмэрүүдийн дотор Монг, Зао Яо зэрэг үндэстэн

ястаны хавтага үүргэвч зэрэг хэрэглэлд эвэр угалз, тал алхан хээ ажиглагдаж байсан бөгөөд хатгамалын арга нь ч бусдаасаа онцлог байв. Вьетнам дахь ястанууд голдуу утас гүйлгэн хатгаж хээлсэн байхад Монг ястан хээг нэвт товшин хатгасан нь Төв Азийнхтай адил байв. Тэд адууг ачаа уналганд эдэлж хэрэглэдэг тул богино шалбуур өмд өмсч шилбээ хээтэй зузаан ороолтоор ороодог. Тэр нь нэг ёсондоо гутлын түрийг орлон дөрөөний сурнаас шилбийг хамгаалдаг нь тодорхой байв гэх мэтээр бичсэнээ энд давтаж.³⁹ Жич Зүүн Өмнөд Азид адуу төвд-бирмийн нүүдэлч малчдаас хүрлийн үед нэвтэрсэн бөгөөд адууг эдлэхэд хэргэлдэг тоног хэрэгсэл ч мөн умраас нэвтэрчээ. Тэр үед умар зүгийн бөө удган нарын тааран нөмрөг Зүүн Өмнөд Азид нэвтэрсэн тухай оросын эрдэмтэн Я.В.Чеснов бас тэмдэглэжээ.⁴⁰

Бүсний тухайд мөн л сэрүүн бүсээс гаралтай хэмээн эрдэмтэд тэмдэглэжээ. Энэтхэг–Хятадын баруун хойт болон Зүүн Химлайн оршин суугчид төдийгүй Зүүн Өмнөд Азийн арлынхан тухайлбал Индонез, Малайзийнханд хүртэл бүс хэрэглэдэг заншил дэлгэрчээ. Энэ нь он цагийн хувьд нэн эрт үед тухайлбал малай-полинез гарвалтай угсаатнууд Зүүн Өмнөд Азийн эх газрын баруун хойт хязгаарт төвд бирм хэлтэн овог аймгуудтай айлсаж байх үед буюу dongson-ы соёл Зүүн Өмнөд Азийн Индонез, Филиппин, Меланез хүртэл тархах болсон тэр үетэй (НТ-ын өмнө ба эхэн үеийн зааг үе) холбон үзэж байна.⁴¹

Зүүн Өмнөд Азид хүрэл зэвсгийн үед угсаатны соёлын асар том өөрчлөлт гарсан гэдэг. Энэ үед өргөн удам нутгийг хамарсан угсаатны соёлын харилцан нөлөөлөл явагдсан. Учир нь Умар зүгээс зарим угсаатнууд өмнө зүг рүү эрчимтэй шилжиж Зүүн Өмнөд Азийн уугуул оршин суугчид далайн арал хойг руу шилжин тархах хөдөлгөөн ихссэн байна. Энэ үеийн алдарт Dongson-ы соёл бол НТӨ 1 дэх мянган жилийн асуудал бөгөөд хамгийн алдартай дурсгал нь Зүүн Өмнөд Азийн өргөн удам нутаг Энэтхэг-Хятадын хойгоос Ява Суматр, Гвинейн арал хүртэлх удам орон зайд тархсан *хүрэл бөмбөр юм*. Үүний дээрх дүрс зургууд НТӨ үеийн Зүүн Өмнөд Азийн угсаатны соёлын олон зүйлийг тайлдаг. Энэ соёл нь умардын угсаатны соёлтой ямар нэг сэжмээр холбоотойг судлаачид бас ажиглажээ. Хан улсын үед (НТӨ III - НТ III Зуун) эзлэн түрэмгийлэх дайнаас дүрвэн умардаас өмнө зүгт шилжин суурьшсан олон овог ястануудын ихэнхи нь Химлайн зүүн хормой дахь овог аймгуудтай айлсан холилджээ. Энэ үед хятадууд хятад биш олон аймгийг эзлэн авахдаа өөрийн соёлыг нэвтрүүлхийн хамт тэдгээр овог аймгуудын олон зүйл соёлыг бас өөрийн болгосон байна. Зүүн Өмнөд Азийн хүрэл зэвсгийн соёл ялангуяа хүрэл бөмбөр Химлайн зүүн хаяа дахь хятад бус овог аймгуудад тархсан байсан бөгөөд тэнд умард Азийнханы хүрэл тогоо

хүрэл хутга мөн хүрсэн байна. Английн эрдэмтэн J.Loewenstein “The “Ordos” Bronze knife from Prehistoric Malaya” хэмээх судалгаандаа Энэтхэг-Хятадын хойгийн хүрэл зэвсгийн соёлын холбоо өмнөд монголын талд хүрч байсныг дурдаад Малайн эргээс Ордосын хүрэл хутаг олдсон тухай бичсэн байна.⁴²

Аливаа эртний худалдааны замууд нь эрт эдүгээгийн хүн зоны соёлын харилцааны зам байдаг. Одоогоос 3000 гаруй жилийн өмнөөс эхэлсэн торгон зам нь торго хоргой, халуун ногоо, ваар шаазан, үнэрт болон үнэт мод зэрэг ховор живэр бараа таваарыг Ази, Ойрхи дорнод, Европын хооронд зөөж байсан худалдааны зам бөгөөд тэр нь өрнө дорнын нийгэм-соёлын солилцоо харилцан нэвтрэлдэг гол зам байв. Энэ үед Төв Ази нь Зүүн Өмнөд Азитай Энэтхэг Хятадын хойгийн умард хэсгээр буюу Төвдийн өндөрлөгийн Зүүн урд хормойгоор хиллэдэг байсан гэж дээр өгүүлсэн. Төв Азийн нутгаас Зүүн Өмнөд Ази ялангуяа Энэтхэг-Хятадын хойгтой холбогдсон худалдааны зам нь монголчуудын нэрлэдэгээр *баруун уртрагийн зам* ба өмнөд торгон зам байв. Нийтийн тооллын өмнөх IV-III зуунд Энэтхэгээс Бирм-Юннань-Сычуань-Сиан хүрдэг Ассамын замыг торгон замын өмнөд салбар гэдэг.⁴³ Жужааны үед одоогийн Сычуань мужаас гаран хятадын төв нутгийн баруун талаар тойрон Сяньбийн нэг салбар болох Тугухунь (Туган) аймгийн нутгаар дайран Монгол, Дунд Азид хүрэх замыг Туган зам гэнэ.⁴⁴ Мөн Төв Азитай хил залгаа умард Энэтхэгээс өмнө зүг чиглэж Малайн олтриг, Яв Суматрийн арал хүрдэг зам ч бий. Эдгээр замууд нь Зүүн Өмнөд Ази болон Өмнөд далайн орнуудтай Төв Азийг холбож тус бүс нутгийн эдийн болон соёлын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж болно.

Төв Ази ба Зүүн Өмнөд Азийнханы оюуны соёлд нөлөөлсөн нэг томоохон хүчин зүйл бол бурханы шашин бөлгөө. Бурханы шашин НТӨ 500 гаруй жилийн тэртээ Балбын өмнөд оронд мэндэлсэн Гаутама Төв Энэтхэгт дэлгэрүүлснээс хойш 200 жилийн дараа Ашок хааны үед улам бадарч хилийн чанад дахь олон оронд түгсэн ажээ. *Бурханы шашин* Монгол ба Зүүн Өмнөд Азийн аль алинд нь эрт дээр үеэс дэлгэрчээ. Бүр НТӨ I мянганы эцсээс эхлэн Төв Ази Умард Энэтхэгийн өргөн уудам газрыг хамарсан нүүдэлчин аймгуудын нүүдэл суудлын их хөдөлгөөн болж өнгөрсөн билээ. Үүний дүнд угсаатны соёлын зүйлс хоорондоо холилдон хутгалдах гүн гүнзгий түүхэн үйл явц бий болжээ. Үүнээс улбаалан Монгол, Энэтхэгийн оюуны соёлын харилцаа эрт дээр цагаас үүсэн бий болсон түүхтэй. Түүний дотор бурханы шашнаар дамжин Энэтхэгийн соёл Төв Ази ба Монголд хүчтэй нөлөөлсөн билээ. Энэтхэгийн бурханы шашин монголын тал нутагт Согд, Уйгураар дамжин эрт үед орж ирсэн бөгөөд V зууны үед Энэтхэгт очсон Хятадын

жуулчин Фа Сянь, VII зууны үед Энэтхэг орсон Хятадын Тансан лам Монголын өмнөд хязгаараар дайран гарахдаа бурханы шашин нэлээдгүй дэлгэрч сүм хийдүүдэд энэтхэг хэлээр ном хурж байсныг дурджээ.⁴⁵ Хожим XVI, XVII зуунд бурханы шашны их хөнгөний урсгал Төвдөөр дамжин өргөн цар хүрээтэй дэлгэрснийг бид мэднэ.

Зүүн Өмнөд Азид бурханы шашин их эртнээс дэлгэрсэн. Зүүн Өмнөд Азийн өмнөд болон төв хэсгээр дэлгэрсэн хиндү шашныг бурханы шашин хүчтэй түрэн нэвтэрсэн цаг хугацаа нь XI зууны үе ажээ. Индонезид харин өмнөд Энэтхэгээс бурханы шашин нэлээд эрт буюу 5-р зуунд дэлгэрч байсан. Харин Вьетнамд бурханы шашин хоёр замаар дэлгэрсэн. Нэг нь НТ-ын эхээр Өмнөд Энэтхэгээс нөгөө нь умардаас. Вьетнамын сурвалж бичигт тэмдэглэсэнээр НТ-ын III зууны эхээр Төв Азийн Согдын орноос K'ang Sen Houei гэгч ламтан вьетнам оронд очиж билэг брамидын хамгийн эртний Ashtasahasrika судрыг орчуулан тархаасан ба мөн III зууны дундуур Төв Азийн Кушаан орноос Kalaruci хэмээх дияанч лам Зүүн Өмнөд Азид очиж дотоод сэтгэлийн дээд бясалгалыг номлогч Saddhama-Samadhi хэмээх судрыг орчуулжээ. Тэр үеэс Вьетнамын оронд Нагаржунайн төв үзэл ихэд дэлгэрснээс гадна дотоод бясалгалын ухаан дэлгэрэн хөгжиж НТ-ын V зуун гэхэд Хятад орны дияанч нараас хол илүү гарсан гэдэг.⁴⁶ Ер монгол хийгээд Зүүн Өмнөд Азийн Вьетнам, Тайланд, Лаос, Бирм, Камбож зэрэг олон оронд бурханы шашин нэн их дэлгэрсэн бөгөөд тэдгээр улс орнуудын нийгмийн суртахууны үндэс суурь нь чухамхүү бурханы шашны үзэл суртахуун болжээ.

Энэ явдал нь Монгол болон Зүүн Өмнөд Азийн ард түмний оюун санааны амьдралд гүн шингэж тухайн ард түмнүүдийн соёл, зан суртахууны хэв загвар ойр дөт болоход ямар нэг хэмжээгээр тус дөхөм үзүүлсэн нь дамжиггүй юм.

Бурханы шашны гол цадиг сургаалуудаар дамжин Төв Ази болон Зүүн Өмнөд Азийнханы утга зохиол урлагт нийтлэг буюу адил төстэй санаа сэдэв, утга өгүүлэгдэхүүн бүхий бүтээл туурвил ч арвин болсон ажээ. Юуны өмнө эртний Энэтхэгээс гаралтай бөгөөд Монголд дэлгэрсэн нэлээд үлгэр Зүүн Өмнөд Азийн ногоон хөвчид мөн тархсан байна. Жишээ нь “Муур багшийн үлгэр”, Сармагчин барыг мэхэлсэн үлгэр”, “Ухаант туулай омогт арсланг хуурч худагт унагасан үлгэр”, “Хулгана зааны хамарт ороод дийлсэн үлгэр” гэх мэт олон үлгэрийг Вьетнам, Лаос, Тайландад яг хэвээр хэлцдэг.⁴⁷ “Тэнгэрийн дагинын үлгэр”, “Зааныг тэмтэрч таасан тухай үлгэр” зэрэг Ганжуур, Данжуур доторхи бурханы цадигуудад болон монголын аман зохиолд тааралддаг үлгэрүүд Зүүн Өмнөд Азид бас дэлгэрсэн байна.

Энэтхэгийн алдарт туульс Рамаяна, Махабхарата бол Төв Ази, Зүүн Өмнөд Азийн аль алинд нь өргөн тархаж, тухайн үндэстний утга

соёлын салшгүй хэсэг болсон байдаг. Ер нь Рамайна, Махабхарата бол Энэтхэг орны түүхэнд Ведийн үе гэж нэрлэгдсэн нийтийн тооллын өмнөх 1500-500 жилийн тэртээ буй болсон туульсын зохиолууд бөгөөд Махабхарата нь нийтийн тооллын өмнөх 1000-аад жилийн тэртээх Энэтхэгийн түүхэн бодит байдалд тулгуурлан зохиогдсон уран сайхны бүтээл хэмээн үздэг. Эдгээр туульс Энэтхэгийн зэргэлдээх улс орнуудын утга соёлд гүн гүнзгий нөлөөлсөн нь нэн эртнээс билээ.

Монгол оронд Рамайна 2 замаар тархсан хэмээн академич Ц.Дамдинсүрэн дурьдсан байдаг. Үүнд, нэн эрт Согд Арийн соёлоор дамжин Төв Ази болон Монгол нутагт тархсан. Нилээд хожуу үед Төвдөөс бурхны шашны утга зохиолоор дамжин Монголд дэлгэрсэн гэжээ. Монголд Рамайна хэд хэдэн хувилбар байдаг бөгөөд сонгодог самгарди (санскрит) эхтэй ойр хувилбар байхаас гадна түүнээс өмнөх эртний Энэтхэгийн хувилбар ч бий хэмээн академич Ц.Дамдинсүрэн дурджээ.⁴⁸

Монголоос алс хол орших Зүүн Өмнөд Азийн Тайланд, Лаос, Бирм, Вьетнам, Камбож зэрэг орнуудад Рамайна, Махабхарата туульсын аль аль нь бярмань болон буддын шашны хамт мөн тэр үед дэлгэрснийг дэлхийн олон судлаачид тэмдэглэсэн байна. Эдгээр туульсад байдаг олон үлгэр Зүүн Өмнөд Азийн төдийгүй Төв Ази, түүний дотор Монголын аман зохиолд дэлгэрч, Монголын аман зохиолын нэгэн хэсэг болжээ.

Хэдийгээр Энэтхэгийн эдгээр эртний туульсын хувьд Монголоос Зүүн Өмнөд Ази, эсвэл Зүүн Өмнөд Азиас Монголд шууд дамжаагүй ч гэсэн Энэтхэг орноос Монгол ба Зүүн Өмнөд Азийн ард түмний аль алины нь утга зохиол, урлагт гүнзгий нөлөөлсөн байна.

Одоо бид Лаос, Тайланд, Вьетнамын умард уулархаг нутгаар оршин суугч *Монг ястаны* зарим зан заншилд Төв Азийн нүүдэлчдийн зан заншилтай төстэй зүйл нэлээдгүй байгааг Вьетнамын проф. Hoang Nam, Су Ноа Ван нарын “Вьетнам дахь Монг ястаны тухай” судалгаанаас авч танилцуулъя. Тэнд бичсэн нь: “Монг нар махыг дангаар чанаж идэх дуртай бөгөөд хатааж борцлох аргатай. Савх хэрэглэдэггүй. Баяр ёслолын үеэр гахай үхэр төхөөрч айл саахалтаа дуудан хамт хооллоно. Ийнхүү хооллохдоо (хасаг айл шиг С.Д.) хоймроо хоолоо дэлгэн овоолж тойрч сууна. Айл бүр цөөн хэдэн адуутай байх бөгөөд түүнийгээ уналга тээвэрт хэрэглэнэ. Адууны махыг хүнсэндээ хэрэглэх дуртай. Эрдэнэ шишийн гурилаар исгэж дарсан архийг өргөн хэрэглэх бөгөөд хулсан аягаар түүнийгээ ууна. Маалинга тариалж түүгээрээ хувцас хэрэглэл нэхнэ. Эмэгтэйчүүд нь алчуур заавал хэрэглэнэ. Тэд том алчуурыг толгойн орой дээр овойлгон ороож хэрэглэнэ. (Хятадын Юнань мужид Хубилай хааны үед очсон монголчуудын тосгонд миний бие 1994 онд очсон бөгөөд тэндхийн

монгол эмэгтэйчүүд мөн заавал алчуур хэрэглэх бөгөөд түүнийгээ толгойн оройд овойлгон өндөр болгодог заншилтай байсан билээ. Тэндхийн эмэгтэйчүүд улаан өнгийн алчуурыг толгой дээрээ мөн овойлгон ороож хэрэглэдэг бөгөөд түүгээр нь монгол ястан гэж хялбар таньдаг хэмээн тэд ярьж байсан билээ) Тэд адууны туурайгаар сам хийж овоолсон үсээ тогтоох бөгөөд үсээ овоолохдоо залгаа хийж сүлжээд толгойн оройд овоолж тогтооно. Цамсны ханцуйг (монгол үзэмчин эмэгтэйн ханцуй шиг... С.Д.) улаан хөх зэрэг олон өнгийн даавуугаар эрээлжлүүлж дасам хийнэ. Сууцныхаа зүүн талыг гэрийн эзний хүндэтгэлтэй тал гэж үзнэ. Гал тогоогоо зүүн талдаа байрлуулна... (Вьетнам, Лаосын уулын район дахь Монг нар саяхан болтол хагас нүүдлийн байдалтай байсан.С.Д.) Буух суух газраа маш сайн сонгоно. Ламаар үзүүлнэ. Өөрсдөө тариа будаа тавьж шинжинэ. Энэ нь нүүдэлчдийн олон зуун жилийн уламжлал ажээ. Хуурай улиралд голдуу нүүнэ. Гэрийн хаалгыг зүүн тийш голдуу харуулна. Гэрийн эзэн ямар жилд төрснөөр байшин барих өдрийг товлон. Баяр ёслолын өдөр нүүхийг цээрлэнэ. Тэгш тоотой өдөр байшин барина. Өглөөний дөрөв буюу зургаан цагт (Бар буюу туулай цагт) сууцаа барихыг хичээнэ. Гол багана босгох ёслол нэн чухал. Багана босгохын өмнө гахай тахиа төхөөрч хоол цай бэлдэж идээ будаа өргөх ёслол үйлдэнэ.

Мөн Төв Азийн нүүдэлчдийн адил бэр хулгайлах ёс, төрсөн ах нь нас барвал авгайг нь төрсөн дүү нь авч суух ёс дээр үед байсны ул мөр одоо ч хадгалагджээ⁷⁴⁹ гэх мэтээр бичсэн байна.

Монг үндэстний тухай хэдэн үг нэмж тодруулья. Энэ үндэстнийг Хятадууд Мяо буюу Mieu (Ногооны талбай дээрх өвс тэмдэг үсгээр тэмдэглэдэг) заримдаа Mieu man гэж доромж утгаар нэрэлж байв. Энэ нэрийг өөрсдөө хэзээ ч хэрэглэж байгаагүй учраас Энэтхэг-Хятадын хойгт байгаа Мяо нарын албан ёсны нэрийг өөрсдий нь нэрлэдэгээр Монг гэх болжээ. Энэ үндэстний тухай Хятадын сурвалжид анх Sui Vei (Шивэй?) гэх аймгийн нэрээр нэрэлж НТӨ III зуунд Цинь Шихуандийн цэрэгтэй байлдсан тухай өгүүлсэн байх аж. Энэхүү Sui Vei аймгийг судалсан олонхи эрдэмтэд одоогийн Монг (Мяо) ястаны дээдэс гэж үздэг бөгөөд зүүн хойт зүгийн нүүдэлчин хэмээн эрдэмтэн Tran Quoc Vuong тэмдэглэжээ. Мяо хэмээх нэр нийтийн тооллын өмнөх эртний хятад домогт үе үе дурдагдаж, Ся улстай байлдах үед хаан нь алагдаж аймаг нь тарж бутарсан тухай дурдаад НТ-ын V зууны үеийг хүртэл ер дахин нэр гарсангүй байсаар Тан улсын үеэс Сычуань, Хунань, Гуй Чжоу орчмоор нутаглах болсон Мяо нарын тухай дурдах болжээ. Тэд түүхэнд төдийлөн дурдагдахааргүй болж сарниад өмнө зүгт шилжин суурьшсаны дараа сая түүхэнд тэмдэглэгдэж эхэлсэн бололтой.

2005 онд Вьетнамын эрдэмтэн Вонг Зуй Куан нэгэн судалгааны өгүүлэлдээ “Монг ястан нь одоогоос 3 мянган жилийн өмнө Шар мөрний буюу Хатан голын хөндийд аж төрж байсан бөгөөд тэр үедээ өөрийн гэсэн төр улстай бичиг үсэгтэй үндэстэн байсан”⁵⁰ ... “нэг үе хятадын харъяанд орж, түүний эсрэг бослого гаргаж тэмцсээр боловч ялагдан өмнө зүг түрэгдэн ирсэн” гэжээ.⁵¹

Ашигласан материал

1. Ё.Отгонбаяр. Нүүдлийн соёл иргэншил ба Монгол. “Дорно-Өрнө” сэтгүүл, 1998, №1
2. World History Vol.I, Prehistory to 1500. Boston, 1990.p.19
3. Ф.П.Коровкин “История древнего мира”., М,1984, 15-р тал
4. Вао “Нянзан”. Вьетнам, 1989
5. Бай Шоули. “Хятадын ерөнхий түүхийн хураангуй тойм”. Шанхай 1980,11-р тал.
6. “Индия в древности”. М, 1964 стр.21.
7. Нгуен Динь Кхоа. “Nhan chung hoc Dong Nam A.” (Зүүн Өмнөд Азийн угсаатны судлал) Ханой, 1983 он.33-р тал
8. “Ардын эрх” сонин. 1997. №248.
9. Ё.Отгонбаяр. Дорно-Өрнө сэтгүүл,1998,№1
10. Шинжааны товч түүх. 1-р дэвтэр. Үрүмч 1985 он. 12-р тал
11. Л.Н.Гуимлев. Их талын хүмүүс ба Байгаль. “Манай Монгол” сэтгүүл УБ., 1999 он №1, 67-р тал
12. Н.Ишжамц. БНМАУ-ын товч түүх. УБ, 1999 он, 48-р тал
13. мөн тэнд. 49-р тал
14. Нгуен Динь Кхоа .154-р тал
15. Нгуен Динь Кхоа. “Nhan chung hoc Dong Nam A.” (Зүүн Өмнөд Азийн угсаатны судлал) Ханой, 1983 он.33-р тал
16. Малые народы Индо-китая М., 1983, Стр.176
17. W.C.Dodd. “The Thai Race ,Elder Brother of the Chinese(Iowa,U.S.A,1923), Kunwjitmatra “The Roots of the Thai People”, ,Manikh Jamsai “Тайландын түүхийн тойм”
18. МАХН-ын 17-р Их хурлын дэлгэрэнгүй тайлан. УБ. 1976. 204-р тал
19. Д.В.Деопик, А.И.Кузнецов. Стр.117
20. Cheng Lufang. Тай үндэстний гарал үүслийн судалгаа. Юнань, 1990.318-р тал
21. Н.Maspero et L.Bozachie.Le groupes sanguins en Indochine du Nord. -Bulletin de L’etude de L’homme .T.III,Fas.2,1940
22. Р.Ф.Итс.Этническая история Юго-Восточной Азии,Л.1972,139-140-р тал
23. L’Histoire du Mieu,Hongkong.1924
24. Les ethnies minoritaires du Vietnam.Hanoi,1993.

25. Dao Duy Anh "Lich su Viet Nam" T.I, Hanoi, 1958, p.57.
L.Aurutsaux "La premiere conquete des pays Annamites"
BEFEO, XXIII, 1923
26. Малые народы Индо-Китая, стр. 177
27. Presence du Royaume Lao. "France-Asie" Revue mensuelle de
culture et de synthese. 1956 Vome XII. p.1048.
28. Р.Ф.Итс. Стр. 170
29. Я.В.Чеснов. Историческая этнография стран Индокитая. М.,
1976. Стр. 225.
30. П.Б.Коновалов. О культуре неба у Монголов. "Банзаровские
чтения" Улан-Удэ, 1992 г. Стр. 27.
31. Мөн тэнд. Стр. 25
32. Собрание сведения о народах обитавших в средней Азии в
древние времена. М.-Л. 1950, Стр 49-59, 58.
33. E. Leach. Political Systems of Haghland Burma, London, 1954.
34. Г. Сүхбаатар. "Монгол Нирун улс", УБ. 1992 он. 21-р тал
35. Я.В.Чеснов. Стр. 159
36. Мөн тэнд. Стр. 137-138
37. Мөн тэнд, Стр. 137
38. Н.Н. Hansen. Some Costumes of Highland Burma of the
Ethnographical Museum of Gottenburg, Goteborg. 1960. p.440
39. Я.В.Чеснов, Стр. 142
40. Үнэн сонин, 1973 он
41. Я.В.Чеснов. Стр. 35
42. J. Loewenstein. "Anthropos", 1961, Bd 56, H, 5-6. pp.936-937
43. Ancient Trades and Cultural Contacts in Southeast
Asia, Bangkok, 1996, p.161
44. Г. Сүхбаатар. Нирун улс. 60-р тал
45. Ш. Бира. Монгол ба Энэтхэг. УБ. 1989, 326-р тал
46. Монгол-Вьетнамын харилцаа 50 жилд. Ред. С. Дашцэвэл, УБ.
2005, 90-р тал.
47. Вьетнам ардын үлгэр домог. УБ. 2005. 10-р тал.
Орч. С. Дашцэвэл.
48. Ц. Дамдинсүрэн. Монголын уран зохиолын харилцаа холбооны
асуудалд, 1987 он 58-р тал
49. Cu Hoa Van, Hoang Nam. "Dan toc Mong o Viet Nam", Ha Noi. 1994
50. Vuong Duy Quang. Nguoi Hmong, Ha Noi. 2005 он, 12-р тал
51. Мөн тэнд 13-р тал